



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/762
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАШНЯМЫН БАТБАЯР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашнямын Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашнямын Батбаярын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Дашнямын Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр (9... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Дашнямын Батбаярт.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2024 оны АИТХ-ын сонгуульд Тариалан сумаас бие даан нэр дэвшигч Хөвсгөл аймгийн Тариалан сумын ЕБС-ийн биологийн багш Хар сүрэгтэн Т.Д.Батбаярын мөрийн хөтөлбөр

**ЭХ ОРОНЧДЫН ХАЛААСАНД ХОГ, СЭТГЭЛД НЬ ГАЛ БАЙДАГ
МОНГОЛ УЛС ХЭРЭГЛЭГЧ БИШ ҮЙЛДВЭРЛЭГЧ БАЙХ УЧИРТАЙ**

НЭГ: Хөвсгөл аймаг хэрэглэгч биш үйлдвэрлэгч аймаг байх ёстой.

1.1. Бүтээн байгуулалтын боломжуудыг аймагтаа нээх.

1.1.1. Тариалан суманд малын дайвар бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуурыг анхан шатны боловсруулалт хийж зах зээлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг гаргадаг байх.

1.1.2. Малчид, ногоочид, баялаг бүтээгчдийн өрхийн үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүнийг ченжийн гар дамжуулахгүйгээр борлуулахад зах зээлийн сувгийг нээж, шат дараалсан олон төрлийн дарамт шахалтыг арилгаснаар өрх бүр үйлдвэрлэгч болох эхлэл тавигдана.

1.1.3. Бага оврын цехүүдийг /арьс ширний, дайвар бүтээгдэхүүний, шилний, төмрийн, төрөл бүрийн хөнгөн үйлдвэрлэлийн г.м/ сумын онцлог байдлыг харгалзан үзэж байгуулах боломжийг нээж өгөх.

1.2. Тариалан сумын нутаг дэвсгэрт байрлах даваа гүвээ болон Мандал, Бадрах багуудын гудамнуудын эвдрэлтэй замуудыг тухайн баг гудамны айл өрхүүдийн иргэдийн оролцоотойгоор засаж янзлах үйл ажиллагааг шат дараалалтайгаар явуулна.

1.2.1. Төвийн 2 багийн үерт идэгдсэн гудамны замуудыг засаж үер урсгах шуудууг хийх

1.2.2. Давааны ар болон Ар тархи баг уруу явах дөт замуудын даваа гүвээ, голын гарам гарцыг дулааны улиралд сааталгүйгээр зорчих нөхцлийг бурдүүлэх боломжоо хангах.

ХОЁР: АИТХ-н төлөөлөгчийн хувьд Тариалан сумандаа хэрэгцээт хөрөнгө оруулалтыг татаж бүтээн байгуулалтанд ашиглах.

2.1. Иргэн төрийн амьд харилцааг нээлттэй болгох.

АИТХ-аас гаргаж буй шийдвэр, тогтоолыг ард иргэдэд нээлттэй ил тодоор хүргэн бодитоор дамжуулж байх. Нээлттэй боловч нийтээрээ мэддэггүй боломжуудыг мэдэгдсэн даруйд нь иргэдэд хүргэх “ЦАГААН ХООЛОЙ - н” үүрэгтэй ажиллана.

2.2. Хог хаягдалгүй хойч үе.

Аймаг болон сумдуудын ЕБС, СӨББ-ын захиргаатай хамтран суралцагчид, асран хамгаалагч болон багш нарын оролцоотойгоор хог хаягдлыг ангилан ялгуулах дадал хэвшил бий болгох үүднээс амьдарч буй орчноосоо үүссэн хаягдлуудыг ангилан долоо хоног бүрийн даваа гарагт сургууль цэцэрлэгтээ ирэхдээ бүгд авчиран цуглуулж тусгайлан бэлтгэсэн газартаа төвлөрүүлдэг болох.

17209511107005
Д.Батбаяр

Тусгайлан бэлтгэсэн газар, түүнд байх энгийн тоног төхөөрөмжүүдийг тухайн сургууль, цэцэрлэгийн байгууллага өөрийн дотоод нөөц боломжоороо бий болгох юм. Дахин боловсруулагдах дахивар хаягдал зөөврөлөхөд овор хэмжээ ихтэй байдгаас шалтгаалж тээврийн зардал их гардаг тул хамгийн түрүүнд бага оврын боломжийн үнэтэй чанар сайтай пресслэгчтэй болох явдал юм. Энэхүү үйл ажиллагааг жигдүүлснээр суралцагчдыг гэр бүл, наиз нөхөд, амьдарч байгаа орчныхоо хүрээнд эх оронч үндэсний үзэл, экологи эдийн засгийн ач холбогдол бүхий сэтгэхүйтэй болгох. Хог хаягдлыг ангилах сэтгэхүйг суулгах, нийгэмд “хог хаягдлын ТЭГ технологийг” нэвтрүүлснээр байгаль экологид сөрөгөөр хандах хандлага буурах гэх мэт тогтвортой хөгжлийн бодлогын томоохон хэд хэдэн зорилтуудыг хангахад оршиж байгаа юм.

2.3. Золбин нохой муургүй болно.

Хөвсгөл аймгийн хэмжээнд энэхүү үйл ажиллагааг сум бүрийн ЗДТГ, ИТХ, мал эмнэлэгийн салбар, оршин суух иргэдийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэх юм. Аймаг суманд золбин нохой муур түр saatuuлан төвлөрүүлэх байрыг байгуулах, тогтмол ажлын байрыг бий болгох явдал юм. Үүнд шаардагдах төсөв хөрөнгийг олон улсын төсөл хөтөлбөр, золбин нохой устгалын зардал, төрийн бус байгууллага болон хувь иргэдтэй хамтрах болон аймаг сумын дотоод нөөц боломжийг ашиглан бий болгох ажил хийгдэнэ. Энэ нь эрүүл монгол хүн үндэсний хөтөлбөр, зоонозын халдварт өвчин, иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдүүлэхэд ихээхэн нэмэр болохуйц үйл ажиллагаа болох юм.

2.4. Ус алтнаас үнэтэй.

Гадаргын усыг сэргээх, түүний ундаргыг тогтоон барих зорилгоор хиймэл цөөрөм, хөрсний чийгийг сайн барих чадвартай бургас, хайлаас, улиасыг гол горхи, булаг шандын эхээр тариалан арчлан хамгаалж, арчилгаанаас гарах хүртэл нь тордох нутгийн иргэдтэй хамтран ажиллаж бут болгоныг үнэлэн авч орон нутгийн байгаль орчны албанд хүлээлгэн өгөх. Энэхүү үйл ажиллагаатай холбоотой зардлыг БОХамгаалах сангаас шийдэж болно.

Мөн дээврийн усны менежментийг сайжруулах төслийг иргэдэд таниулан хэрэгжүүлэх алхамыг шат дараалалтайгаар хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

2.5. “Аргал төсөл”

Энэхүү төслийг санаачлан эхлүүлснээр үр дүнг сайжруулж хангай нутгийн ой модыг хамгаалах, гадаргын усны дутагдлыг багасгаж хөрс цөлжих үйл ажиллагаанд саад тавих тодорхой ажлын байр бий болох.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын ЕБС-ийн биологийн багш Хар сүрэгтэн Т.Д.Батбаярын олон нийтийн сувгууд

Facebook хаяг:
Facebook хуудаснууд:

Дашнямын БАТБАЯР
Өрхийн үйлдвэрлэл ба аж ахуй
ХаСүБи 89.5
Хөвсгөл аймаг Тариалан сумын ЕБС
Олны хувь оломугчийн далај - Хөвсгөл Тариалан
Харилцах утас 88384828



Т.Д.Батбаяр
Х.Сүрэгтэн